



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар П/276

Хэрлэн сум

Генерал цолтнуудад хүндэтгэл үзүүлэх,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.13 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад цэргийн дээд цол олгож эхэлсний 79 жилийн ойг тохиолдуулан Хэнтий аймгаас төрөн гарсан генерал цолтнуудад хүндэтгэл үзүүлсүгэй.


2. Генерал цолтнуудад хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг Засаг даргын нөөц сангийн нэг удаагийн шинжтэй, урьдчилан төлөвлөх боломжгүй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д зөвшөөрсүгэй.

3. Генерал цолтнуудын түүхэн замнал, алдар гавьяаг сурталчлах арга хэмжээ зохион байгуулж ажиллахыг Цэргийн штабын дарга (хурандаа Н.Хүрэлээ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 01-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

ГЕНЕРАЛ ЦОЛТНУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ
ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Нэг бүрийн үнэ	Тоо	Нийт үнэ	Хянасан
1	Хүндэтгэл	500.000	8	4.000.000	
Нийт				4.000.000	